



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ТӨЛӨВЛӨЛТӨНД
ДОТООД ХЯНАЛТ ХИЙСЭН ТАЙЛАН

2022 он
АГУУЛГА

1. Удирдамж
2. Тайлан
3. Зөвлөмж

**ТӨРИЙН АЛБАНЫ СТАНДАРТ, АЛБАН ХААГЧДЫН ТӨЛӨВЛӨЛТӨНД
ДОТООД ХЯНАЛТ ХИЙСЭН ТУХАЙ ТАЙЛАН**

2022.03.15

Дотоод хяналт шалгалтад хамрагдсан объект : Байгаль орчин, аялал жуулчлалын газрын албан хаагчид, сумын байгаль хамгаалагч

Дотоод хяналт шалгалтын хугацаа :

Энэхүү дотоод хяналтын зорилго нь Төрийн албаны тухай хууль, төрийн албаны стандарт, журмын хэрэгжилт, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг сайжруулах, зөвлөн туслах, ажлын зохион байгуулалтыг сайжруулахад оршино.

Газрын даргын баталсан удирдамжийн дагуу хяналт шалгалтыг хийж гүйцэтгэв.

Хяналт шалгалтанд газрын нийт 2 мэргэжилтэн, Сүмбэр сумын байгаль хамгаалагч, нягтлан бодогч, бичиг хэрэг хамрагдсан. хамруулаагүй.

Хяналт шалгалтыг ярилцлага, баримт бичгүүдийг үзэж танилцах, зөвлөн туслах, холбогдох баримтуудыг татан авч үзэж шинжлэх зэрэг арга зүйг ашигласан.

Албан хаагчдаас 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг авч хянаж үзсэн. авна. Төрийн албан хаагчдын төлөвлөлтөнд дараах нийтлэг алдаа байна.

1. Арга хэмжээ болон хугацааг хэт ерөнхий төлөвлөсөн.
2. Бодлогын баримт бичгүүдийн уялдааг сайн хангаагүй.
3. Үр дүн, үр нөлөө багатай арга хэмжээ төлөвлөсөн.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 тоот тушаалын 5 дугаар хавсралт “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын 1.1. “Бодлогын баримт бичиг болон хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ”-г хэрэгжүүлэх зорилгоор тухайн албан хаагч гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээг тодорхойлохдоо дараах арга зүйг мөрдлөг болгоно.

Үүнд: 1.1.2. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, стратеги төлөвлөгөөнд тусгагдсан ижил нэршилтэй, ижил утгатай, бие биеэ агуулсан утгатай зорилт, арга хэмжээг нэгтгэж, нэг арга хэмжээ болгон тодорхойлох; 1.1.3. Гүйцэтгэлийн зорилт болон зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ хоорондын уялдааг хангах; гэж заасныг баримтлан төлөвлөх шаардлагатай.

1.1.4. Арга хэмжээний шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинг хагас, бүтэн жилээр тодорхойлох;

- Эхний хагас жил, сүүлийн хагас жилийн хүрэх түвшинг холбогдох аргачлалын дагуу нарийвчлан тогтоосон.

Байгууллагын гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээг бусад нэгж, эсхүл өөрийн нэгжийн албан хаагчтай хамтран хэрэгжүүлэх болсон тохиолдолд тухайн албан хаагч арга хэмжээ, түүний шалгуур үзүүлэлтийг дангаараа хэрэгжүүлж болохуйц байдлаар нарийвчлан тодорхойлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах;

Дээрх зааврын дагуу сургалт хийж, зөвлөн тусласан. Маш сайн уншиж төлөвлөлт, тайлагналтаа сайжруулах шаардлагатай.

Албан хаагч бүрээр танилцуулъя.

Р.Цэндмаа Аялал жуулчлал, тусгай хамгаалалттай газар нутаг, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн

Шалгуур үзүүлэлт	Тайлбар
Төлөвлөлт	Төрийн албан хаагчийн төлөвлөлт хийхэд шаардлагатай хууль, журам, зааврыг уншуулж танилцуулан тайлбарлаж 2022 оны төлөвлөлтийг хамтран хийсэн. Шинээр орсон албан хаагч тул шинэ эр томилогдсон албан хаагчийг дадлагажуулах хуудсыг дагуу зөвлөгөө өгсөн.
Ололт, дутагдал	Сурах хүсэл эрмэлзэлтэй, холбогдох хууль, журам, зааврыг уншиж танилцсан.

Ой, цөлжилт, биологийн олон янз байдлын асуудал хариуцсан мэргэжилтэн Т.Дашцэдэн

Шалгуур үзүүлэлт	Тайлбар
Төлөвлөлт	Төрийн албан хаагчийн төлөвлөлт дунд. 2022 он байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд орсон арга хэмжээг нарийвчлан төлөвлөсөн ч хэт ерөнхий, тэрбум үндэсний хөдөлгөөнтэй холбоотой шинэ санаачилга хэрэгжүүлэх арга хэмжээ бага төлөвлөсөн. Аймгийн Засаг даргын БОАЖС-тй байгуулсан хамтран ажиллах гэрээнд тусгагдсан байгалийн ургамал нөхөн сэргээх тарималжуулах 1 шинэ ажлыг төлөвлөгөөнд тусгасан. Албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан Цөлжилтийн судалгаа, хөрсний бохирдлын байдалд дүн шинжилгээ хийж, нөхөн сэргээлт хийх, хяналт тавих зэрэг арга хэмжээг уялуудлан хэрэгжүүлэх шаардлагатай.
Ололт, дутагдал	<ul style="list-style-type: none"> - Ололт: Журам, зааврын дагуу төлөвлөлтөө сайжруулсан. - Дутагдал: шинэ санаачилга гаргах

Байгаль орчны үнэлгээ, усны асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Намуунцэцэг

Үзүүлэлт	Тайлбар
----------	---------

Төлөвлөлт	Төрийн албан хаагчийн төлөвлөлт дунд. Хүрээлэн буй орчны бохирдол, байгалийн гамшиг, газрын асуудал хариуцсан мэргэжилтэнтэй уялдаатай ажиллах шаардлагатай. Төлөвлөлт хэт ерөнхий.
Ололт, дутагдал	Ололт: Журам, зааврын дагуу төлөвлөлтөө сайжруулсан. Дутагдал: Шинэ санаачилга гаргах, идэвхи санаачилгатай байх

Байгаль хамгаалагч С.Түмэндэлгэр

Шалгуур үзүүлэлт	Тайлбар
Төлөвлөлт	Төрийн албан хаагчийн төлөвлөлт дунд. Сумын байгаль очрчны мэргэжилтэнтэй нягт хамтран ажиллаж, мэдээлэл сайн солилцож, төлөвлөлтийн уялдааг хангах
Ололттай тал	Ололт: Журам, зааврын дагуу төлөвлөлтөө сайжруулсан. Дутагдал: Шинэ санаачилга гаргах

Нягтлан бодогч Ц.Цэрэнчимэд, архив, бичиг хэргийн эрхлэгч Д.Отгонбаяр нарын төлөвлөгөө сайн төлөвлөгдсөн.

Албан хаагчид урьдчилсан зөвлөмжийн дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөөг сайжруулан 3 сарын 02-нд 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг газрын даргаар батлуулсан.

ТӨРИЙН АЛБАНЫ СТАНДАРТ, АЛБАН ХААГЧДЫН ТӨЛӨВЛӨЛТ, ТАЙЛАГНАЛТАНД ДОТООД ХЯНАЛТ ХИЙЖ, АЖЛЫН ҮР ДҮНГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААРХ ЗӨВЛӨМЖ

Газрын даргын 2022 оны 2 сарын 22-ны өдөр баталсан удирдамжийн хүрээнд төрийн албаны стандарт, албан хаагчдын төлөвлөлтөнд хийсэн хяналт шалгалтын ажлын үр дүнгээр дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

№	Зөвлөмж	Хэрэгжүүлэх хугацаа
1	Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолын хавсралт “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам, заавар, бодлогын баримт бичгүүд, албан тушаалын тодорхойлолтыг тогтмол уншиж судалж байх	14 хоног тутам
2	Төлөвлөлтийг тухай бүр сайжруулах /Хугацааг тодорхой болгох, тусгагдаагүй ажлыг журмын дагуу нэмэлт ажлаар тайлагнах/	2022.05.25
3	Төрийн албан хаагчийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд онцгой анхаарч хувийн төлөвлөлт хийх	Сар бүр

4	<p>Чиг үүрэгтэй холбоотой хууль тогтоомж, үндэсний хөтөлбөр, дэд хөтөлбөр, бусад эрх зүйн баримт бичгүүдийг бүрэн хяналтанд авч тайлагнах /жагсаалт хийх/ Өөрөөр хэлбэл хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд холбогдох хуулийн хэрэгжилтэнд дүн шинжилгээ хийх ажлыг төлөвлөж зохион байгуулах</p> <p>Засгийн газрын 2021.12.14-ний өдрийн 374 дүгээр тогтоол “Тогтоолын хавсралтанд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” /2020 оны 206 дугаар тогтоолд өөрчлөлт орсон./</p>	<p>Хүснэгт 2022.05.05 /Сар бүр, хагас бүтэн жил/</p>
5	Шинэлэг ажил санаачилан хэрэгжүүлэх	Хагас, бүтэн жил

Тайлан бичсэн:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, хүний нөөц, дотоод ажил хариуцсан
ахлах мэрэгжилтэн

Б.Гандулам

Хянасан:

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын
дарга

Д.Мөнх-Эрдэнэ